ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 25 өдөр Дугаар 6/15 Хэрлэнбаян-Улаан тосгон

Ш.Насанбуянг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, дээд хэмжээг шинэчлэн тогтоох тухай " 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам", Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 05 сарын 02-ны 26 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шурагийн Насанбуянг 2025 оны 04 дүгээр сарын 25-ний өдрөөс Захирагчийн ажлын албаны галчаар томилсугай.

2. Галч Насанбуянгийн үндсэн цалинг ТҮ-1 буюу 954000 төгрөгөөр тогтоож, орон нутгийн нэмэгдэл 60%-иар нэмж цалинжуулахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОТГОНБАЯР

1823120002 9073515